БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНБУЛАГ СУМЫН ЭМТ-ИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Аудитын код:** БНА-2021/14/СТА-ТШЗ


Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням

Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn

“Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: Tsetsegmaa_1961@yahoo.com


Баянхонгор
2021 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.


005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан..... 6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... 10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ..... 12
3.Аудитын тайлан..... 13
3.1. Ерөнхий зүйл..... 13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт..... 13
3.4. Материаллаг байдал..... 14
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 14
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт..... 15
3.7. Шилэн дансны мэдээлэл ..... 18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 18
3.9. Аудитын илрүүлэлт ..... 18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил..... 18
Аудитын зөвлөмж..... 19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ..... 19
Менежментийн захидал..... 19
5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 21

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

# 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2021.02.18 № 2/32

танай ____________ -ны №____________ -т

БАЯНХОНГОР АЙМГИЙН БАЯНБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА О.ГАНДИЙМАА ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил

2021 А4 ТООТ

005020921

гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **12,341,171.00** | **24,476,925.00** |
| **33** | **АВЛАГА** | 576,385.00 | 00.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 576,385.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 11,764,786.00 | 24,476,925.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 3,439,663.00 | 6,552,905.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 3,439,663.00 | 4,994,663.00 |
| 35130 | Эм боох материал | 00.00 | 1,558,242.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 7,875,123.00 | 17,924,020.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,499,320.00 | 1,432,320.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,429,300.00 | 12,036,300.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,662,600.00 | 800,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 589,150.00 | 911,570.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,694,753.00 | 2,743,830.00 |
| 35600 | Мал амьтад | 450,000.00 | 00.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,296,663,982.56** | **1,276,375,488.74** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,296,663,982.56 | 1,276,375,488.74 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,295,177,682.56 | 1,274,944,188.70 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,260,025,835.00 | 1,260,025,835.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -45,650,649.48 | -89,034,662.28 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 34,806,434.00 | 66,306,434.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -10,207,432.34 | -18,633,504.74 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж | 113,577,856.00 | 142,291,779.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -65,684,703.97 | -92,752,863.69 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 20,533,929.50 | 21,421,929.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -12,223,586.15 | -14,680,758.09 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,486,300.00 | 1,431,300.04 |
| 39301 | Програм хангамж | 870,000.00 | 670,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -650,000.00 | -504,999.96 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,266,300.00 | 1,266,300.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,309,005,153.56** | **1,300,852,413.74** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **2,366,300.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 2,366,300.00 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 2,366,300.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 2,366,300.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,309,005,153.56** | **1,298,486,113.74** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,309,005,153.56 | 1,298,486,113.74 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 192,097,841.00 | 192,097,841.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч: - төрийн | 192,097,841.00 | 192,097,841.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,047,318,038.63 | 1,036,798,998.81 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,047,318,038.63 | 1,047,318,038.63 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -10,519,039.82 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 69,589,273.93 | 69,589,273.93 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,309,005,153.56** | **1,300,852,413.74** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **374,641,520.00** | **494,281,186.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,125,000.00** | **77,629,816.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 4,125,000.00 | 77,629,816.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 4,125,000.00 | 77,629,816.00 |
| 1E+06 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 4,125,000.00 | 77,629,816.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **370,516,520.00** | **416,651,370.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 332,339,400.00 | 364,270,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 332,339,400.00 | 364,270,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 83,400.00 | 12,932,760.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 83,400.00 | 12,759,960.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 172,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 23,320,400.00 | 22,090,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 23,320,400.00 | 22,090,400.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 14,773,320.00 | 17,358,210.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 14,773,320.00 | 17,358,210.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **423,282,490.51** | **504,800,225.82** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **423,282,490.51** | **504,800,225.82** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 423,177,532.51 | 488,619,256.82 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 240,010,234.68 | 274,356,368.00 |
| 210101 | Үндсэн цалин | 239,997,734.68 | 183,107,907.00 |
| 210102 | Нэмэгдэл | 12,500.00 | 72,420,261.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 18,828,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,289,949.00 | 36,915,406.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,512,049.00 | 25,951,806.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,259,300.00 | 2,740,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 2,192,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 548,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,518,600.00 | 5,481,800.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,580,234.00 | 24,066,850.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,090,284.00 | 2,589,550.00 |
| 210302 | Түлш, халаалт | 15,089,950.00 | 21,077,300.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000.00 | 400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 41,741,447.00 | 27,189,790.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,807,820.00 | 3,857,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,772,590.00 | 20,716,740.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,306,800.00 | 1,347,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 95,000.00 | 908,250.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 284,500.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 4,155,800.00 | 00.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 5,603,437.00 | 75,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 23,902,654.00 | 24,384,844.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 17,422,243.00 | 16,948,574.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,382,811.00 | 6,236,270.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 97,600.00 | 1,200,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 652,200.00 | 1,544,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 432,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 652,200.00 | 1,112,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,380,000.00 | 1,456,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,380,000.00 | 1,456,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 483,400.00 | 14,360,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 83,400.00 | 13,960,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 66,137,413.83 | 84,345,298.82 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,354,506.00 | 2,954,882.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 63,782,907.83 | 81,390,416.82 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 104,958.00 | 16,180,969.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 12,759,960.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 12,759,960.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 5,416.00 | 55,650.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,416.00 | 55,650.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 99,542.00 | 3,365,359.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 99,542.00 | 3,365,359.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-48,640,970.51** | **-10,519,039.82** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,021,994.83 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,021,994.83 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -1,021,994.83 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-49,662,965.34** | **-10,519,039.82** |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **370,516,520.00** | **416,651,370.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **370,516,520.00** | **416,651,370.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 332,339,400.00 | 364,270,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 332,339,400.00 | 364,270,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 83,400.00 | 12,932,760.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 83,400.00 | 12,932,760.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 23,320,400.00 | 22,090,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 23,320,400.00 | 22,090,400.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 14,773,320.00 | 17,358,210.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 14,773,320.00 | 17,358,210.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **370,516,520.00** | **411,375,370.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **370,516,520.00** | **411,375,370.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **370,411,562.00** | **395,194,401.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 227,968,178.00 | 273,779,984.00 |
| 210101 | Үндсэн цалин | 168,920,600.00 | 187,971,184.00 |
| 210102 | Нэмэгдэл | 46,682,110.00 | 66,980,600.00 |
| 210104 | Урамшуулал | 12,365,468.00 | 18,828,200.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 28,497,300.00 | 36,915,405.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,460,100.00 | 25,951,805.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,259,300.00 | 2,740,900.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,807,400.00 | 2,192,700.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 451,900.00 | 548,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,518,600.00 | 5,481,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,314,984.00 | 20,034,750.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,090,284.00 | 2,589,550.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,824,700.00 | 17,045,200.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000.00 | 400,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 24,494,890.00 | 26,282,640.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,182,900.00 | 1,140,900.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,077,090.00 | 20,719,940.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,306,800.00 | 1,471,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 928,100.00 | 2,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 00.00 | 950,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 25,231,604.00 | 13,998,690.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 17,442,075.00 | 5,822,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,749,529.00 | 5,726,690.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,040,000.00 | 2,450,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 18,051,000.00 | 1,180,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 13,651,000.00 | 68,000.00 |
| 210602 | Тавилга | 1,400,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,000,000.00 | 1,112,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,380,000.00 | 1,456,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,380,000.00 | 1,456,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,050,600.00 | 14,360,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,650,600.00 | 13,960,700.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 400,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 11,423,006.00 | 7,186,232.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,423,006.00 | 7,186,232.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **104,958.00** | **16,180,969.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 12,759,960.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 12,759,960.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 5,416.00 | 55,650.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,416.00 | 55,650.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 99,542.00 | 3,365,359.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 99,542.00 | 3,365,359.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **5,276,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **5,276,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **5,276,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 5,276,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 5,276,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-5,276,000.00** |
| 9 | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 0.00 |
| 10 | **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 0.00 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 192,097,841.00 | 69,589,273.93 | 1,096,981,003.97 | 00.00 | 1,358,668,118.90 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **192,097,841.00** | **69,589,273.93** | **1,096,981,003.97** | **00.00** | 1,358,668,118.90 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -7,283,530.42 | 00.00 | -7,283,530.42 |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **192,097,841.00** | **69,589,273.93** | **1,047,318,038.63** | **00.00** | 1,309,005,153.56 |
| D01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **192,097,841.00** | **69,589,273.93** | **1,047,318,038.63** | **00.00** | 1,309,005,153.56 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **192,097,841.00** | **69,589,273.93** | **1,047,318,038.63** | **00.00** | 1,309,005,153.56 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -10,519,039.82 | 00.00 | -10,519,039.82 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **192,097,841.00** | **69,589,273.93** | **1,036,798,998.81** | **00.00** | 1,298,486,113.74 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 403,752,600.00 | 400,297,601.00 | -3,454,999.00 | 99.1 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 403,752,600.00 | 400,297,601.00 | -3,454,999.00 | 99.1 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 403,752,600.00 | 400,297,601.00 | -3,454,999.00 | 99.1 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 276,526,400.00 | 273,779,984.00 | -2,746,416.00 | 99.0 |
| 210101 | Үндсэн цалин | 188,281,600.00 | 187,971,184.00 | -310,416.00 | 99.8 |
| 210102 | Нэмэгдэл | 69,416,900.00 | 66,980,600.00 | -2,436,300.00 | 96.5 |
| 210104 | Урамшуулал | 18,827,900.00 | 18,828,200.00 | 300.00 | 100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 37,012,400.00 | 36,915,405.00 | -96,995.00 | 99.7 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,951,300.00 | 25,951,805.00 | 505.00 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,765,300.00 | 2,740,900.00 | -24,400.00 | 99.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,212,200.00 | 2,192,700.00 | -19,500.00 | 99.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 553,100.00 | 548,200.00 | -4,900.00 | 99.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,530,500.00 | 5,481,800.00 | -48,700.00 | 99.1 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,090,400.00 | 20,034,750.00 | -55,650.00 | 99.7 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,590,400.00 | 2,589,550.00 | -850.00 | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 17,100,000.00 | 17,045,200.00 | -54,800.00 | 99.7 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,806,100.00 | 26,282,640.00 | -523,460.00 | 98.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 1,140,900.00 | -59,100.00 | 95.1 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,086,300.00 | 20,719,940.00 | -366,360.00 | 98.3 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,569,800.00 | 1,471,800.00 | -98,000.00 | 93.8 |
| **2105** | **Нормативт зардал** | 14,022,000.00 | 13,998,690.00 | -23,310.00 | 99.8 |
| 210502 | Хоол, хүнс | 5,750,000.00 | 5,726,690.00 | -23,310.00 | 99.6 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,457,200.00 | 1,456,000.00 | -1,200.00 | 99.9 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,457,200.00 | 1,456,000.00 | -1,200.00 | 99.9 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10400200.00 | 10392232.00 | -7,968.00 | 99.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,400,200.00 | 10,392,232.00 | -7,968.00 | 99.9 |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮ-ЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 403,752,600.00 | 400,297,601.00 | -3,454,999.00 | 99.1 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 364,270,000.00 | 360,904,641.00 | -3,365,359.00 | 99.1 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 364,270,000.00 | 360,904,641.00 | -3,365,359.00 | 99.1 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 22,090,400.00 | 22,034,750.00 | -55,650.00 | 99.7 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 22,090,400.00 | 22,034,750.00 | -55,650.00 | 99.7 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 17,392,200.00 | 17,358,210.00 | -33,990.00 | 99.8 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 17,392,200.00 | 17,358,210.00 | -33,990.00 | 99.8 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **83400.00** | **12,932,760.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **83400.00** | **12,932,760.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 83400.00 | 172,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 83400.00 | 172,800.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 0.00 | 12759960.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 12,759,960.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | 12,759,960.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 12932760.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 12,932,760.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 83400.00 | 12,759,960.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 0.00 | 172,800.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг ЭМТ-ийн дарга О.Гандиймаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 22-ноос 2021 оны 01 дүгээр сарын 25–ны хооронд "Глобал капитал аудит" ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЭМТ нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 136 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЭМТ нь тайлант хугацаанд "Хүнд амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, жигд, хүртээмжтэй хүргэж, эрүүл мэндийн тэргүүлэх төв болох" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЭМТ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны 4 дүгээр улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 439848.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8796.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөөгүй болно.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 969851.5 мянган төгрөг болж өмнөх оноос 15389.6 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар тайлант оны үр дүнгээр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 12341.2 | 24476.9 | 12135.7 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 576.4 | | -576.4 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 11764.8 | 24476.9 | 12712.1 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1296663.9 | 1276375.5 | -20288.4 |
| Үндсэн хөрөнгө | 1431080.4 | 1491982.3 | 60901.9 |
| Хуримтлагдсан элэгдэл | -134416.4 | -215606.8 | -81190.4 |
| Нийт хөрөнгө | 1309005.1 | 1300852.4 | -8152.7 |
| Өр төлбөр | 0.00 | 2366.3 | 2366.3 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1309005.1 | 1298486.1 | 10519.0 |



005 Төрийн аудитын байгууллага Зөрчилгүй санал дүгнэлт

| | | | |
|---|---|---|---|
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1309005.1 | 1300852.4 | -8152.7 |

Авлага дансны өмнөх оны үлдэгдэл 576.4 мянган төгрөгийг барагдуулж , тайлант онд үүссэн авлагыг тухай бүр барагдуулж авлагагүй ажилласан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 24476.9 мянган төгрөг болж 12712.1 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотой ЭМГ болон иргэн, ААНБ-аас 8663.5 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл , хамгаалах хэрэгсэл, шатахууныг оны эцсээр үнэ төлбөргүй олгосон, ЭМГ-аас олгосон тендерийн эмээс 1558.2 мянган төгрөгийн эм зарцуулагдаагүй үлдсэн, өөрийн туслах аж ахуйгаас 375.0 мянган төгрөгийн мах орлогод авч зарцуулаагүйтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1491982.3 мянган төгрөг болж 60901.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 5276,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, ЭМЯ-наас УТХО-аар 31500.0 мянган төгрөгийн Пургон автомашин олгосон, ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрээр 24900.0 мянган төгрөгөөр бэлтгэгдсэн Мобайл технологи төхөөрөмжийг үнэ төлбөргүй шилжүүлсэн нь үндсэн хөрөнгийн дүнгийн өсөлтөд нөлөөлсөн байна.

Тайлант онд 200.0 мянган төгрөгийн өртөг бүхий ашиглалтгүй байсан архивын программыг данснаас хассанаас өөр хөрөнгө хасагдаагүй, үндсэн хөрөнгө актлаагүй байна.

Биет бус хөрөнгө данс тайлант онд 200.0 мянган төгрөгөөр буурсан нь архивын программыг хассантай холбоотой бөгөөд дээрх дансны үлдэгдэл цэвэр дүнгээр 1431.3 мянган төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1298486.1 мянган төгрөг бөгөөд өмнөх оноос 10519.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр 364270.0 мянган төгрөгийн , орон нутгийн төсвөөс 22090.4 мянган төгрөгийн, ЭМД-аас 17358.2 мянган төгрөгийн, нийт 403718.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, нэмэлт санхүүжилтээр 12759.9 мянган төгрөгийн, ЭМГ-аас вакцин тээврийн зардлын 172.8 мянган төгрөгийн орлого тус тус төвлөрснийг бүртгэл тайланд бүрэн тусгасан байна.

Батлагдсан төсөвт нийт зардал 403752.6 мянган төгрөг болж өмнөх оноос 27900.6 мянган төгрөгөөр буюу 23.7 хувиар өссөн байна. Энэ нь Засгийн газраас төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэнтэй холбоотой цалин , НДШ-ийн зардал 54229.9 мянган төгрөгөөр өсч, ЭМТ-үүдийн эмийг ЭМГ-аас тендер зарлаж нийлүүлэх болсноос нормативт зардал 11232.9 мянган төгрөгөөр, эд хогшил бэлтгэх болон урсгал засварын зардал 14801.0 мянган төгрөгөөр буурч батлагдсанаас шалтгаалжээ.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЭЗЭМШИГЧ САНАЛ ДҮГНЭЛТ

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд аудит хийхэд системийн дээд байгууллагаас өгсөн чиглэлийн дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээний статистик тоон мэдээллийг ЭМЯ-д хүргүүлж түүнд үндэслэн төсвийн төсвийг боловсруулдаг тул байгууллагаар төсвийн төсөл боловсруулдаггүй гэсэн

тайлбарыг аймгийн ЭМГ-ын төсвийн мэргэжилтэн өгсөн бөгөөд тухайн байгууллага дээр төсвийн төсөл нэгтгэсэн дүнгээр боловсруулаагүй байна. 2019 оны шилэн дансны мэдээллээс авч үзэхэд төсвийн төсөл дараах байдалтай байна.Үүнд:

2020 оны төсвийн төсөл

| Д.Д | Зардлын төрөл | Хэмжих нэгж | Төсвийн төслөөр дүн | Батлагдсан дүн | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Цалингийн зардал | Мян.төгрөг | 302660.3 | 276526.4 | -26133.9 | |
| 2 | Төлбөр хураамж | Мян.төгрөг | 137.8 | | -137.8 | |
| 3 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлс төлбөр | Мян.төгрөг | 766.1 | 14187.9 | 13421.8 | |
| 4 | Гэрэл цахилгаан | Мян.төгрөг | 4800.0 | 2590.4 | -2209.6 | |
| 5 | Түлш халаалт | Мян.төгрөг | 20650.0 | 17100.0 | -3550.0 | |
| 6 | Цэвэр бохир ус | Мян.төгрөг | 2400.0 | 400.0 | -2000.0 | |
| 7 | Урсгал засвар | Мян.төгрөг | 14604.0 | 3250.0 | -11354 | |
| 8 | Шуудан холбоо | Мян.төгрөг | 1906.8 | 1569.8 | -337.0 | |
| | **ДҮН** | | **347925.0** | **315624.5** | **-32300.0** | |

Эх сурвалж: 2019 оны Шилэн дансанд байршуулсан мэдээллээс авав.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн 8 төрлийн зардлын төсвийн төслөөс дүнгээрээ 32300.0 мянган төгрөг хасагдаж батлагдсан бөгөөд бусад зардлын хувьд статистик тоон мэдээлэлд үндэслэн ЭМЯ төсвийг боловсруулж байгаа нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1."Төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаг төсвийн шууд захирагч нь жилийн төсвийн төслөө жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор харьяалах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх" гэсэнтэй нийцэхгүй байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 403752.6 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай зориулалтын шилжүүлгээр 364270.0 мянган төгрөгийн , орон нутгийн төсвөөс 22090.4 мянган төгрөгийн, ЭМД-аас 17358.2 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийт 403718.6 мянган төгрөгийн санхүүжилт авсан ба ЭМД-аас авах санхүүжилтийг 34.0 мянган төгрөгөөр дутуу авч , урсгал үйл ажиллагаанд 400297.6 мянган төгрөгийг зарцуулж 3421.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 400297.6 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 2843.4 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол

зардлыг 55.6 мянга, хангамж бараа материалын зардлыг 523.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71602 хөтөлбөрийн 81603 буюу үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ арга хэмжээний цалин, НДШ-ийн зардал 2843.4 мянга, хангамж хангамж бараа материалын зардал 523.5 мянган



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

төгрөгөөр, 80109 арга хэмжээний зардал 55.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Хүснэгт 2.ТГ-ийн бүлэгтэй тайлан

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **ХӨТӨЛБӨР 71602** | | | | |
| **АРГА ХЭМЖЭЭ 80109** | | | | |
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **22090400** | **22090400** | | |
| Гэрэл цахилгаан | 2590400 | 2589550 | 850 | 100 |
| Түлш халаалт | 17100000 | 17045200 | 54800 | 99.7 |
| Цэвэр бохир ус | 400000 | 400000 | 0 | 100 |
| Урсгал засвар | 2000000 | 2000000 | | |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | | | 55650 | |
| **АРГА ХЭМЖЭЭ 80302** | | | | |
| **Тусгай зориулалтын шилжүүлгийн** | **-13,705,800.00** | **-13,705,800.00** | 0 | 100 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,655,600.00 | 1,655,600.00 | 0 | 100 |
| Багаж, техник, хэрэгсэл | 1,250,000.00 | 1,250,000.00 | 0 | 100 |
| Аудит бат, зэрэглэл тогтоох | 400,000.00 | 400,000.00 | 0 | 100 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 10,400,200.00 | 10,392,232.00 | 7,968.00 | |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 7,968.00 | -7,968.00 | |
| **АРГА ХЭМЖЭЭ 81603** | | | | |
| **Хандив тусламж-дотоод** | **-17,392,200.00** | **-17,358,210.00** | **-33,990.00** | **99.8** |
| **Тусгай зориулалтын шилжүүлгийн** | **-350,564,200.00** | **-350,564,200.00** | **0** | **100** |
| Үндсэн цалин | 188,281,600.00 | 187,971,184.00 | 310,416.00 | 99.83513 |
| Нэмэгдэл | 69,416,900.00 | 66,980,600.00 | 2,436,300.00 | 96.49034 |
| Урамшуулал | 18,827,900.00 | 18,828,200.00 | -300 | 100.0016 |
| Нийгмийн даатгалын шимтгэл | 25,951,300.00 | 25,951,805.00 | -505 | 100.0019 |
| Тэтгэмжийн даатгал | 2,765,300.00 | 2,740,900.00 | 24,400.00 | 99.11764 |
| ҮОМШ-ний даатгал | 2,212,200.00 | 2,192,700.00 | 19,500.00 | 99.11852 |
| Ажилгүйдлийн даатгал | 553,100.00 | 548,200.00 | 4,900.00 | 99.11408 |
| Эрүүл мэндийн даатгал | 5,530,500.00 | 5,481,800.00 | 48,700.00 | 99.11943 |
| Бичиг хэрэг | 1,200,000.00 | 1,140,900.00 | 59,100.00 | 95.075 |
| Тээвэр, шатахуун | 21,086,300.00 | 20,719,940.00 | 366,360.00 | 98.26257 |
| Шуудан, холбоо, интернэт | 1,569,800.00 | 1,471,800.00 | 98,000.00 | 93.75717 |
| Хог хаягдал зайлуулах, хортон | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0 | 100 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, | 950,000.00 | 950,000.00 | 0 | 100 |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,166,400.00 | 4,166,400.00 | 0 | 100 |
| Хоол, хүнс | 5,750,000.00 | 5,726,690.00 | 23,310.00 | 99.59461 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,450,000.00 | 2,450,000.00 | 0 | 100 |
| Дотоод албан томилолт | 1,457,200.00 | 1,456,000.00 | 1,200.00 | 99.91765 |
| Бусад нийтлэг АҮТ хураамж | 13,787,900.00 | 13,787,900.00 | 0 | 100 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 0 | 3,357,391.00 | -3,357,391.00 | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн

гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газрын нэмэлт санхүүжилтийн 100031620401 тоот дансанд аймгийн ЭМГ-аас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэгийн 12759.9 мянга, сорьц тээвэрлэлтийн зардалд 172.8 мянган, нийт 12932.7 мянган төгрөг төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулж холбогдох дансаар тайлагнасан байна.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 149 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан ба хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | | |
| 4 | Сар бүр | 5 | 36 | 36 | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 96 | | |
| | Нийт | 29 | 151 | 149 | 0 | 2 |

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй бөгөөд ХХОАТ-ын илүү төлөлтийн 441.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоогдсоныг 2020.05.29-ний өдөр төлж барагдуулсан, өмнөх оны авлага барагдуулах 523,9 мянган төгрөгийн албан шаардлагыг хэрэгжүүлж хариуг 2020.06.09.ний 58 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналын дахин үнэлгээний дүнгээс *57267,3* мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн зөрчил илэрсэн боловч уг зөрчлийг тодруулан шалгахад 2012 он, 2016 онуудад хийгдсэн дахин үнэлгээний тайлангууд олдохгүй байгаагаас алдаанд тооцож залруулах боломжгүй гэж үзэн ОНӨГ-тай хамтарч шийдвэрлэх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэсэн болно.

**Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил илрээгүй болно.

**Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэлтэй холбоотой 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

### 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

### Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. *Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт: Хөрөнгийн дахин үнэлгээний бичилт зөв эсэхийг санхүүгийн тайлангийн хөрөнгийн дахин үнэлгээ дансанд тусгасан дүнг үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, ОНӨГ-ын нэгтгэл тайлантай тулган баталгаажуулахад санхүүгийн тайланд хөрөнгийн дахин үнэлгээ данс 57267,3 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан нь хэдэн онд үнэлэгдсэн ямар хөрөнгийн дахин үнэлгээ бүртгэлтэй байгаа болон ямар хөрөнгийн дахин үнэлгээ хэрэгжсэн эсэх нь тодорхойгүй байна.*

*Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.44 Дахин үнэлгээний нэмэгдлийг хэрэгжсэн үед нь хуримтлагдсан үр дүн данс руу шилжүүлнэ гэснийг зөрчсөн байна.*

1.2. *Эрсдэл: Нягтлан бодох бүртгэл стандартын дагуу хөтлөгдөөгүй байх*

1.3. *Өгсөн зөвлөмж: Төрийн болон төрийн өмчит байгууллагуудад 2012 он, 2016 онуудад хийгдсэн дахин үнэлгээний тайлангуудаас тулгалт хийн ОНӨГ-тай хамтарч данснаас хассан хөрөнгийн дахин үнэлгээ хасаагүй тохиолдолд хасах тохируулах бичилтийг хийх, дахин үнэлгээ хэрэгжсэн бол Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөх дансны заавар"-ын 4.44-д " Дахин үнэлгээний нэмэгдлийг хэрэгжсэн үед нь хуримтлагдсан үр дүн данс руу шилжүүлнэ" гэсний дагуу залруулгыг хийх*

1.4. *Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

*2.1.Илрүүлэлт: Батлагдсан төсөвт зардлыг дүнгээр нь хэтрүүлээгүй боловч зардлын ангиллаар авч үзэхэд шатахууны зардалд 21086.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж 20719.9 мянган төгрөгийг зарцуулсан атлаа 2366.3 мянган төгрөгийн өртэй гарсан нь төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг хасаж тооцоход батлагдсан төсвийг 2000.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.*

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", 41 дүгээр зүйлийн 41.2.2- д "Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах" гэснийг тус тус зөрчсөн байна.*

*2.2.Эрсдэл: Төсвийг арвилан хэмнэлттэй үр ашигтай зарцуулаагүй,Төсвийн тухай хууль зөрчих*

*2.3.Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулж, Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн өр, авлагагүй ажиллах*

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*2.3. <u>Өгсөн зөвлөмж</u>: Батлагдсан төсөвт багтаан үйл ажиллагаа явуулж, Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлэн өр, авлагагүй ажиллах*

*2.4. <u>Байгууллагаас өгсөн хариу тайлбар:</u>Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР — Д.ЦЭЦЭГМАА
Огноо: 2021.02.15

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР — А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.15

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.15

6417143544
БЮА0067 9007423

## 5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| **Огноо** | **Аудитын нэр:** | Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | **Аудитын код:** |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/14/СТА-ТШЗ |
| **Шалгагдсан байгууллагын нэр:** | | Баянхонгор аймгийн Баянбулаг сумын ЭМТ | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | *Санхүүгийн тайлангийн хөрөнгийн дахин үнэлгээ дансанд тусгасан дүн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, ОНӨГ-ын нэгтгэл тайлангаас 57267,3 мянган төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан.* | 0.00 | Зөвлөмж өгөх | Дарга | О.Гандиймаа , |
| 2 | *Батлагдсан төсөвт зардлыг дүнгээр нь хэтрүүлээгүй болович зардлын ангиллаар авч үзэхэд шатахууны зардалд 21086.1 мянган төгрөгийн төсөв батлагдаж 20719.9 мянган төгрөгийг зарцуулсан атлаа 2366.3 мянган төгрөгийн өртэй гарсан нь төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг хасаж тооцоход батлагдсан төсвийг 2000.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.* | 2000.0 | Зөвлөмж өгөх | Дарга | О.Гандиймаа |
| **ДҮН** | | **2000.0** | | | |



005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ